



УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
С.Зоригийн гудамж-2, Утас: +976-77111027
И-мэйл: info@fchm.edu.mn

2026.03.02 № 1/397

танай _____-ны № _____-т

Үнийн санал авах тухай

Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн Өндөр өртөгт тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай эмнэлгийн хэрэгсэлд "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасны дагуу үнийн санал ирүүлнэ үү.

Үнийн саналыг 2026 оны 03 дугаар сарын 04-ний 12 цаг хүртэл хүлээн авна.

Мэйл хаяг: procurement@fchm.edu.mn

Хаяг: УНТЭ-ийн 1 давхар 103 тоот

Хавсралт 1 хуудастай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



П.АНХТУЯА

ATA9996 90771
9823058128

142260660

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий
захирлын 2026 оны 03 дугаар сарын 02-ны
өдрийн 1337 дугаар албан бичгийн хавсралт



№	Эмнэлгийн хэрэгсэл, хиймэл цорго, протез, ортопедийн хэрэгслийн нэршил	Хэмжээ	Техникийн тодорхойлолт	Тоо ширхэг
1	2 хөндийн пейсмеркер төхөөрөмж /MRI боломжтой/		Электрод холболт нь IS1 стандарттай, бүтэн биеийн MRI (1.5T ба түүнээс дээш) боломжтой, MRI-д оношилгоонд зориулсан тохиргоотой. Тосгуурын фибрилляцийг үүсэх үед дарангуйлан арилгах горимтой, пейсмеркер хамааралтай болон хамааралгүйгээр аюултай хэм алдагдал үүссэнийг бүртгэн авч 2 ба түүнээс дээш минутын бичлэгийг хадгалдаг байх; Үйлдвэрийн тохиргоогоор ажиллах хугацаа 12 ба түүнээс дээш жил, үйлдвэрлэлийн баталгаат хугацаа 5 ба түүнээс дээш жил, мэдрэг байдлын тохиргоо болон цочроох байдлын тохиргоо нэг туйлт, хоёр туйлт боломжтой байх, баруун тосгуур, ховдлыг цочроох вольтын хэмжээг төхөөрөмж өөрөө автоматаар шалгаж, өөрийгөө тохируулах чадвартай байх, ховдлын өөрийн агшилтыг дэмжих алгоритмтай, зүрхний суурь цохилтын тоо ба пейсмеркерээр удирдаж эхлэх суурь цохилтын тоог өөр өөрөөр тохируулах боломжтой байх, PSA шалгагчтай байх.	2
2	Тосгуурын электрод		Шулуун хэлбэртэй, бүтэн биеийн MRI (1.5T ба түүнээс дээш) хийх боломжтой, хэмжээ 6F-ээс ихгүй, 53 см дээш 3 төрлийн уртын сонголттой, идэвхтэй бэхэлгээтэй, polyurethane, silicone холимог бүрхүүлтэй, электродын оролт IS1 стандарттай, электродын уртын тэмдэглэгээтэй, стеройдын хэсэгтэй, хөдөлгөөнгүй болгож бэхлэхэд зориулсан бэхэлгээ хийх хамгаалалтын хэсэгтэй, биполяр туйлтай байх.	2
3	Ховдлын электрод		Шулуун хэлбэртэй, бүтэн биеийн MRI (1.5T ба түүнээс дээш) хийх боломжтой, хэмжээ 6F-ээс ихгүй, 58 см доод тал нь 4 төрлийн уртын сонголттой, идэвхтэй бэхэлгээтэй, polyurethane, silicone холимог бүрхүүлтэй, электродын оролт IS1 стандарттай, электродын уртын тэмдэглэгээтэй, стеройдын хэсэгтэй, хөдөлгөөнгүй болгож бэхлэхэд зориулсан бэхэлгээ хийх хамгаалалтын хэсэгтэй, биполяр туйлтай байх.	2
4	Электродын хатгалтын интродюсер /ширхгээр/		Гүний венийн хатгалтын зүү, тариур, чиглүүлэгчийг багтаасан багц байх, тэлэгч нь интродюсертэй тогтвортой бэхлэгдэх түгжээтэй, 6F, 7F, 8F, 10F, 11F, 12F өргөний сонголттой, 14 см урттай, урагдан салдаг байх.	4

----- ооо ООО ооо -----